



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/65

Жаргалант

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийннэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 29.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-н өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдийн А/99 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах сумын хэмжээнд төрийн байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг “2020 оны 04 дүгээр сарын 30-ны” өдөр хүртэл сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд түр зогсоож, холбогдох арга хэмжээ авахыг ЕБС-ийн захирал /Н.Чимэд-Очир/, 1-р цэцэрлэгийн эрхлэгч /С.Оюунчимэг/ нарт даалгасугай.

3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг тухай бүр, шуурхай зохион байгуулж ажиллахыг ЭМТ-ийн дарга /А.Шинэ-Од/-д даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоол, энэхүү захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч /П.Буяндэлгэр/, БО-ны асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Төрбат/ нарт даалгасугай.

5. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээллэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ЗДТГ-ын дарга /Г.Бямбадалай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ОТГОНДАЛАЙ

